



**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙДЫН  
ТУШААЛ**

2005 оны 03 сарын 10 өдөр

Дугаар 49.

Улаанбаатар хот

**Заавар, загвар батлах тухай**

Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай Монгол Улсын хуулийн 8 дугаар зүйлийн 1.4 дэх хэсэгт заасныг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. "Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийн загвар"-ыг 1 дүгээр хавсралтаар, "Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл боловсруулах заавар"-ыг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

Хоёр. Энэ тушаалын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Төсвийн бодлого, зохицуулалтын газар /Д.Баасанхүү/, Төрийн сангийн газар /Х.Пүрэвсүрэн/, Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Цогтбаатар/-т, эдгээр заавар, загварыг 2005 оны 04 дугаар сарын 01-нээс эхлэн мөрдөж ажиллахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт үүрэг болгосугай.



Н.АЛТАНХУЯГ

Сангийн сайдын 2005 оны 49 дугаар  
тушаалын 1 дүгээр хавсралт

УХА0011

## ТӨСВИЙН ТӨСӨЛ

### [ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭ]-НИЙ ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ

..... оны төсвийн жил

200. оны .....дугаар сар

## Агуулга

Хуудасны дугаар

Төсвийн ерөнхийлөн захирагчийн мэдэгдэл

Нэр томьёо ба товчилсон үгийн тайлбар

Хэсэг 1: Дунд хугацааны стратегийн зорилтууд, төсвийн төслийн уялдаа ба төсвийн хандлага

Хэсэг 1.1: Дунд хугацааны стратегийн зорилтууд

Хэсэг 1.2: Дунд хугацаанд хэрэгжүүлэх зарлиг, хууль, тогтоол, захирамж, бусад холбогдох шийдвэрүүд

Хэсэг 1.3 Дунд хугацааны стратегийн зорилт ба төсвийн төслийн уялдаа

Хэсэг 1.4 Төсвийн цаашдын хандлага, авах арга хэмжээ

Хэсэг 2: [Эрхлэх асуудлын хүрээ]-ний ТЕЗ-ийн орлогын төсвийн төсөл, холбогдох тайлбар

Хэсэг 2.1: Улсын төсөвт оруулах орлогын төсвийн төсөл, холбогдох тайлбар

Хэсэг 2.2: Өөрийн орлого, бусад нэмэлт орлогын төсвийн төсөл, холбогдох тайлбар

Хэсэг 3: [Эрхлэх асуудлын хүрээ]-ний ТЕЗ-ийн зарлагын төсвийн төсөл, холбогдох тайлбар

Хэсэг 3.1: Эрхлэх асуудлын хүрээний ТЕЗ-ийн зарлагын төсвийн төслийн хураангуй, холбогдох тайлбар

Хэсэг 3.2: Бүтээгдэхүүний ангийн төсвийн төсөл, холбогдох тайлбар

Хэсэг 3.3: Тэтгэвэр, тэтгэмж ба бусад шилжүүлгийн зардлын төсвийн төсөл, холбогдох тайлбар

Хэсэг 3.4: Өмчлөлийн эрхийн хэрэгжүүлэхэд гарах зардлын төсвийн төсөл, холбогдох тайлбар

Хэсэг 3.5: Хөрөнгө оруулалтын төсвийн төсөл, холбогдох тайлбар

Хэсэг 3.7: ТЕЗ-ийн төсвийн төсөл - Эдийн засгийн ангилалаар

Хэсэг 3.6: Улсын шинжтэй зарлагын төсвийн төсөл, холбогдох тайлбар

Хэсэг 4: ТЕЗ-ийн нэгдсэн төсөвлөсөн санхүүгийн тайлан, холбогдох тайлбар

Хэсэг 4.1: Төсөвлөсөн баланс

Хэсэг 4.2 Төсөвлсөн үр дүнгийн тайлан

Хэсэг 4.3: Төсөвлөсөн мөнгөн гүйлгээ тайлан

Хэсэг 4.4: Төсөвлөсөн өмчийн өөрчлөлтийн тайлан

Хэсэг 5: ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах аж ахуйн тооцоотй байгууллагуудын төсвийн хураангуй нэгтгэл, холбогдох тайлбар

Хэсэг 6: Хавсралтууд



## [Төсвийн Ерөнхийлөн Захирагч ]-ийн мэдэгдэл

[Эрхлэх асуудлын хүрээ] –ийн Төсвийн ерөнхийлөн захирагч миний ТБУСТХ-ийн 30 дугаар зүйлд заасны дагуу боловсруулсан 200..-200.. оны дунд хугацааны төсвийн төслийг хянан үзэж баталж өгөхийг Монгол Улсын Засгийн газар, Улсын Их Хуралд хүсэлт болгон хүргүүлж байна. Төсөлд тусгагдсан бүтээгдэхүүн нийлүүлэлтийн ба бусад санхүүжилтийн арга хэмжээ нь тус салбарын болон Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чухал хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна.

[Эрхлэх асуудлын хүрээ] –ийн ТЕЗ-ийн дунд хугацааны стратегийн зорилт, хүрэх үр дүн, нийлүүлэх бүтээгдэхүүн, төсөвлөсөн орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн төслийг дагалдах хэсгүүдэд дэлгэрэнгүй харуулсан болно.

ТБУСТХ-ийн 30 дугаар зүйлийн 1.1-д заасны дагуу энэхүү өргөн барьж буй баримт бичиг нь Монгол улсын 200..- 200.. оны Төсвийн Хүрээний Мэдэгдэл болон улсын төсвийн төсөлтэй уялдсан болно.

[Эрхлэх асуудлын хүрээ] –ийн ТЕЗ-ийн 200.. оны төсөвлөсөн нийт орлого ..... мянган төгрөг бөгөөд хураангуй байдлаар харуулбал:

- ..... мянган төгрөгийн орлогыг улсын төсөвт оруулна;
- ..... мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого
- .....мянган төгрөгийн туслах үйл ажиллагааны орлого
- .....мянган төгрөгийн бусад орлогыг өөрийн үйл ажиллагаагаар олно.

[Эрхлэх асуудлын хүрээ] –ийн ТЕЗ-ийн 200.. оны төсөвлөсөн нийт зарлага ..... мянган төгрөг бөгөөд хураангуй байдлаар харуулбал:

- .... мянган төгрөг буюу нийт төсвийн ....%-ийг бүтээгдэхүүн нийлүүлэх зардалд
- ..... мянган төгрөг буюу нийт төсвийн ....%-ийг хөрөнгө оруулалтын зардалд
- ..... мянган төгрөг буюу нийт төсвийн ....%-ийг өмчлөлийн эрхийг хэрэгжүүлэх зардалд
- .... мянган төгрөг буюу нийт төсвийн ....%-ийг тэтгэвэр, тэтгэмж ба бусад шилжүүлгийн зардалд
- ◆ ..... мянган төгрөг буюу нийт зардлын ....%-ийг улсын шинжтэй зарлагад зарцуулна.

Миний үзэж байгаагаар, энэхүү төсвийн төсөл нь иж бүрэн, бодитой, үнэн зөв, төсөвт томоохон нөлөө үзүүлэх бодлого болон бусад нөхцөл байдлыг бүрэн хамруулсан, Монгол улсын хууль тогтоомжид нийцсэн болно.

Гарын үсэг:

Нэр

[Эрхлэх асуудлын хүрээ] –ийн Төсвийн ерөнхийлөн захирагч

Он сар өдөр

## Нэр томьёо ба товчилсон үгийн тайлбар

### Нэр томьёо

#### Бүтээгдэхүүн

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн байгууллага болон бусад этгээдээс нийлүүлэх тоо хэмжээ, хугацаа, чанар, зардал зэрэг Үр дүнгийн гэрээнд тусгасан шалгуур үзүүлэлтээр тодорхойлогдох ажил, үйлчилгээ

### Товчилсон үгс

СЯ

Сангийн яам

ТБ

Төсвийн байгууллага

## Хэсэг 1. /Эрхлэх асуудлын хүрээ/-ний ТЕЗ-ийн дунд хугацааны стратегийн зорилт, төсвийн төслийн уялдаа ба төсвийн хандлага

### 1.1 Дунд хугацааны стратегийн зорилтууд

ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд Засгийн газраас дэвшүүлсэн үйл ажиллагааны зорилтуудыг ханган биелүүлэхийн тулд 200..-200.. онд дараахь стратегийн зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

**Стратегийн зорилт 1:**

- Хүрэх үр дүн 1.1
- Хүрэх үр дүн 1.2
- Хүрэх үр дүн 1.3

**Стратегийн зорилт 2:**

- Хүрэх үр дүн 2.1
- Хүрэх үр дүн 2.2

**Стратегийн зорилт 3:**

- Хүрэх үр дүн 3.1
- Хүрэх үр дүн 3.2
- Хүрэх үр дүн 3.3

**1.2 Дунд хугацаанд хэрэгжүүлэх зарлиг, хууль, тогтоол, захирамж, бусад холбогдох шийдвэрүүд**

**1.3 Дунд хугацааны стратегийн зорилт ба төсвийн төслийн уялдаа**

[Эрхлэх асуудлын хүрээний нэр] -ийн ТЕЗ-ийн дэвшүүлсэн дунд хугацааны стратегийн зорилтууд нь төсвийн төсөлтэй хэрхэн уялдаж буйг Хүснэгт 1-д харуулав.

Хүснэгт 1

**Монгол улсын [Эрхлэх асуудлын хүрээний нэр] -ийн  
Төсвийн Ерөнхийлөн Захирагч: .....**

Төсвийн төслийн нийт дүн: ..... мянган төгрөг  
Бүтээгдэхүүний нийт өртөг: .....мянган төгрөг



#### 1.4 Төсвийн цаашдын хандлага, авах арга хэмжээ

- Улсын төсөвт оруулах орлогын хандлага, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
- Өөрийн орлогын хандлага, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
- Төсвийн нийт зардлын хандлага, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
- Бүтээгдэхүүний өртгийн хандлага, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
- Хөрөнгө оруулалтын зардлын хандлага, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
- Тэтгэвэр, тэтгэмж ба бусад шилжүүлгийн зардлын хандлага, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
- Өмчлөлийн эрхийг хэрэгжүүлэхэд гарах зардлын хандлага, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

## 2. /Эрхлэх асуудлын хүрээ/-ний ТЕЗ-ийн орлогын төсвийн төсөл, холбогдох тайлбар

---

2.1 Улсын төсөвт оруулах орлогын төсвийн төсөл, холбогдох  
тайлбар

ХҮЧӨРТ 2

### 3.2 Өөрийн орлогын төсөл, тэдгээрийн тайлбар

[Эрхлэх асуудлын хүрээнд] ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн байгууллагын олох өөрийн орлогын төвлөгөөг байгууллага бураэр Хавсралт-Дэлгэрэнгүй Үзүүлсэн багэд ТЕЗ-ийн олох нийт өөрийн орлогын хураануйт дор харуулав.

ХҮЧНЭГТ 3

### Хэсэг 3. [Эрхлэх асуудлын хүрээ]-ний ТЕЗ-ийн зарлагын төсвийн төсөл

3.1 /Эрхлэх асуудлын хүрээ/-ний ТЕЗ-ийн зарлагын төсвийн төслийн хураангуй нэгтгэл, холбогдох тайлбар

Хүснэгт 4

Д/д		Төсвийн зардлын төрөл	Нийт зардлын дүн (мян. төг)
1	1	Бүтээгдэхүүний зардал:	
	1	Бүтээгдэхүүний анги	
	2	Бүтээгдэхүүний анги	
	3	Бүтээгдэхүүний анги	
	4	Бүтээгдэхүүний анги	
	5	Бүтээгдэхүүний анги	
	6	Бүтээгдэхүүний анги	
2	1	Тэтгэвэр, тэтгэмж ба бусад шилжүүлгийн зардал ТАХ-ын нэг хүүхдийн сургалтын төлбөр	
	2	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	
3	1	Өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэхэд гарах зардал Олон улсын байгууллагын гишүүний татвар	
	2	Ургал засвар	
	3	Бүтцийн өөрчлөлтийн зардал	
4	1	Хөрөнгө оруулалт Улсын төсвийн хөрөнгө оруулалт: Тоног төхөөрөмж Эд хогшил Их засвар	
	1	Өөрийн хөрөнгөөр хийх хөрөнгө оруулалт:	
		<b>Улсын шинжтэй зарлага</b>	
		<b>НИЙТ ЗАРЛАГЫН ТӨСӨВ</b>	

### 3.2 Бүтээгдэхүүний ангийн төсвийн төсөл, холбогдох тайлбар

ХҮЧНЭГТ 5

ХҮЧӨРТ 6

Эрхлэх асуудлын хурээ/-ний ундсан чиглэлийн үзүүлэлтүүд

33.3. Тэтгэвэр, тэтгэмж ба бусад шилжүүлгийн зардлын төсвийн төслөл, холбогдох тайлбар

Xylochart 7

3.4 Өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэхэд гарах зардлын төсвийн төслөл, холбогдох тайлбар

ХҮЧӨРТ 8

Төсөв	Санал	Ся- наас хянасан	УИХ-аас баталсан	200.. оны төсөв		200.. оны таамаг- лап	Тайлбар
				Төсвийн хүрээ	Төсвийн хүрээг- дэж буй гүйцэт- гэл	200.. оны төсөв	
Өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэхэд гарах зардлын төрөл	200.. оны гүйцэт- гэл	200.. оны гүйцэт- гэл	200.. оны хүлээг- дэж буй гүйцэт- гэл	200.. оны хүлээг- дэж буй гүйцэт- гэл	200.. оны төсөв	200.. оны төсөв	200.. оны таамаг- лап
Өмчлөгчийн хэрэгжүүлэх зардал	Эрхийг НИЙТ						

### 3.5 Хөрөнгө оруулалтын төсвийн төсөл, холбогдох тайлбар

ХҮЧЭЛТ 9

3.6 [Эрхлэх асуудлын хүрээ]-ний ТЕЗ-ийн зарлагын төсөл /эдийн засгийн ангилалаар/, холбогдох тайлбар

Xylo 10

### 3.7 УЛСЫН ШИНЖТЭЙ ЗАРЛАГЫН ТЕСӨЛ, ХОЛБОГОХ ТАЙЛБАР

XCHART 1

## Хэсэг 4. /Эрхлэх асуудлын хүрээ/-ний ТЕЗ-ийн нэгдсэн төсөвлөсөн санхүүгийн тайлан, холбогдох тайлбар

### 4.1 ТЕЗ-ийн нэгдсэн төсөвлөсөн баланс, холбогдох тайлбар

Хүснэгт 12

(мян. төгрөг)

Данс- ны дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ	200.. оны гүйцэ- тгэл	200.. оны гүйцэт- гэл	200.. оны ХБГ	200.. оны төсөв	200.. оны таамаг- лал	200.. оны таамаг- лал
	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</b>						
	<b>МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ</b>						
	<b>АДИЛГАХ ХӨРӨНГӨ</b>						
	Кассад байгаа бэлэн мөнгө						
	Төгрөг/жижиг мөнгөн сан						
	Гадаад валют						
	Банкннд байгаа бэлэн мөнгө						
	Төсвийн харилцах						
	Төгрөг						
	Гадаад валют						
	Богино хугацаат хадгаламж						
	Төгрөг						
	Замд яваа мөнгөн хөрөнгө						
	Төгрөг						
	<b>АВЛАГА</b>						
	Төлбөртэй үйлчилгээний						
	<b>авлага</b>						
	Бусад авлага						
	<b>УРЬДЧИЛГАА</b>						
	Урьдчилгаа тооцоо						
	Урьдчилж гарсан зардал						
	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>						
	Түүхий эд материал						
	Дусаагүй үйлдвэрлэл						
	Бэлэн бүтээгдэхүүн						
	Хангамжийн материал						
	Мал, амьтад						
	Бусад						
	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>						
	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН						
	<b>ДҮН</b>						
	ЭРГЭЛТИЙН БУС						
	<b>ХӨРӨНГӨ</b>						
	<b>БУСАД ХӨРӨНГӨ</b>						
	Хойшлуулсан зардал						
	Урьдчилж гарсан урт хугацаат						
	зардал						
	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>						
	Биет хөрөнгө						
	Барилга, байгууламж						
	Авто-тээврийн хэрэгсэл						
	Машин, тоног төхөөрөмж						
	Тавилга, аж ахуйн эд хогшил						
	<b>Батлан хамгаалахын</b>						
	<b>зориулалттай</b>						
	тоног төхөөрөмж						
	Түүх соёлын дурсгалт зүйлс						
	Номын фонд						

		Бусад ундсэн хөрөнгө					
		Дуусаагүй барилга, байгууламж					
		Биет бус хөрөнгө					
		Гудвилл					
		Зохиогчийн эрх					
		Программ хангамж					
		ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН					
		<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>					
		ӨР ТӨЛБӨР					
		<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>					
		Богино хугацаат зээл					
		Өглөг					
		Ажиллагчидтай холбогдсон тооцоо					
		Бараа үйлчилгээний зардлын тооцоо					
		Зээлийн хүүгийн тооцоо					
		Татаас, санхүүжилтийн тооцоо					
		Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон тооцоо					
		Бусад өглөг					
		Урьдчилж орсон орлого					
		Урьдчилгаа – Төсвийн татаас					
		Бусад урьдчилж орсон орлого					
		<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>					
		<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>					
		Урт хугацаат зээл					
		<b>УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>					
		<b>ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН</b>					
		ЭЗНИЙ ӨМЧ					
		Засгийн газрын сан					
		Орон нутгийн сан					
		Хуримтлагдсан үр дүн					
		Өмнөх үеийн үр дүн					
		Тайлант үеийн үр дүн					
		Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү					
		ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН					
		<b>ӨР ТӨЛБӨР, ЭЗНИЙ ӨМЧИЙН ДҮН</b>					

**4.2 ТЕЗ-ИЙН НЭГДСЭН ТӨСӨВЛӨСӨН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН, ХОЛБОГДОХ ТАЙЛБАР**

Хүснэгт 13

(мян. төгрөг)

Данс- ны дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	200.. оны гүйцэ- тгэл	200.. оны гүйцэт- гэл	200.. оны ХБГ	200.. оны төсөв	200.. оны таамаг- лал	200.. оны таамаг- лал
	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО						
	<u>ТАТААС БА САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u>						
	Улсын төсвөөс						
	Орон нутгийн төсвөөс						
	Бусад төсөвт байгууллагаас						
	Нийгмийн даатгалын сангаас						
	ЭМДС-ийн шилжүүлэг						
	Бусад тусгай зориулалтын сангаас						
	Төрийн АХ нэг хүүхдийн зардал (түр)						
	<u>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</u>						
	Олон улсын байгууллагын тусlamж						
	Төсөвт байгууллагаас						
	Бусад байгууллагаас						
	<u>ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</u>						
	Байгууллагын өмчтэй холбогдсон орлого						
	Хүүгийн орлого						
	Түрээсийн орлого						
	Төсөвт байгууллагын төлбөртэй үйлчилгээний орлого						
	Үндсэн үйл ажиллагааны орлого						
	Үндсэн бус ажил үйлчилгээний орлого						
	Торгууль, төлбөрийн орлого						
	<u>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</u>						
	<u>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ</u>						
	<u>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</u>						
	Цалин, хөл болон нэмэгдэл урамшил						
	Цалин						
	Цалингийн тусгай нэмэгдлүүд						
	Нийгмийн даатгал						
	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл						
	Эруул мэндийн даатгалын хураамж						
	<u>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</u>						
	Нийтлэг чанартай зардал						
	Тусгай материал, үйлчилгээний зардал						
	<u>ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР</u>						
	<u>ТАТААС, САНХҮҮЖИЛТ</u>						
	Засгийн газрын дотоод санхүүжилт						
	Гадаад шилжүүлэг						
	Бусад санхүүжилт						
	<u>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)</u>						
	<u>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</u>						
	<u>ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО</u>						
	Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (бодит)						
	Хөрөнгө худалдсаны олз						

	<u>Үндсэн хөрөнгө худалдсаны олз</u>			
	Бараа материал, нөөцийн бараа худалдсаны олз			
	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (IV)			
	ҮНДСЭН БУС ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ			
	<u>Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз (бодит)</u>			
	<u>Хөрөнгө худалдсаны гарз</u>			
	<u>Үндсэн хөрөнгө худалдсаны гарз</u>			
	<u>Бараа материал, нөөцийн бараа худалдсаны олз</u>			
	<u>Бараа материал</u>			
	<u>Нөөцийн бараа</u>			
	<u>Хөрөнгийн бусад зардал</u>			
	Ойжуулалтын зардал			
	Геологи хайгуулын зардал			
	Байгаль хамгаалах төслийн зардал			
	Их засварын зардал			
	Хөрөнгийн бусад зардал			
	Үндсэн бус үйл ажиллагааны зардлын дүн (V)			
	Үйл ажиллагааны нийт үр дүн (VI)=(III)+(IV)-(V)			

**4.3 ТЕЗ-ИЙН НЭГДСЭН ТӨСӨВЛӨСӨН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН, ХОЛБОГОДОХ  
ТАЙЛБАР**

Хүснэгт 14

(мян. төгрөг)

Данс- ны дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	200.. оны гүйцэ- тгэл	200.. оны гүйцэт- гэл	200.. оны ХБГ	200.. оны төсөв	200.. оны таамаг- лал	200.. оны таамаг- лал
	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ						
	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО						
	<u>ТАААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</u>						
	<u>Улсын төсвөөс</u>						
	Ургал						
	Хөрөнгийн						
	<u>Орон нутгийн төсвөөс</u>						
	Ургал						
	Хөрөнгийн						
	<u>Бусад төсөвт байгууллагаас</u>						
	Ургал						
	Хөрөнгийн						
	<u>Нийгмийн даатгалын сангаас</u>						
	ЭМДС-гийн шилжүүлэг						
	<u>Бусад тусгай зориулалтын сангаас</u>						
	Төрийн АХ нэг хүүхдийн зардал (түр)						
	<u>ТУСЛАМЖИЙН ОРЛОГО</u>						
	<u>Олон улсын байгууллагын тусламж</u>						
	Ургал						
	Хөрөнгийн						
	<u>Төсөвт байгууллагаас</u>						
	Ургал						
	Хөрөнгийн						
	<u>Бусад байгууллагаас</u>						
	<u>ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО</u>						
	<u>Байгууллагын өмчтэй холбогдсон орлого</u>						
	Хүүгийн орлого						
	Түрээсийн орлого						
	<u>Төсөвт байгууллагын үйлчилгээний орлого</u>						
	Үндсэн үйл ажиллагааны орлого						
	Үндсэн бус ажил үйлчилгээний орлого						
	<u>Торгууль, төлбөрийн орлого</u>						
	<u>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</u> (I)						
	<u>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА</u>						
	<u>АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ</u>						
	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил						
	Цалин						
	Цалингийн тусгай нэмэгдлүүд						
	<u>Нийгмийн даатгал</u>						
	Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл						
	Эрүүл мэндийн даатгалын хураамж						
	<u>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</u>						
	<u>Нийтлэг чанартай зардал</u>						
	Бичиг хэргийн зардал						
	Гэрэл цахилгааны зардал						
	Түлш, халаалтын зардал						
	Цэвэр, бохир усны зардал						

	Байрны түрээсийн зардал					
	Тээвэр, шатахууны зардал					
	Шуудан холбооны зардал					
	Холбооны суваг ашигласны зардал					
	<u>Томилотын зардал</u>					
	Дотоод					
	Гадаад					
	Ном, хэвлэлийн зардал					
	Аж ахуйн материал худалдан авах зардал					
	Ургал засварын зардал					
	Сургалт семинарын зардал					
	Төлбөр, хураамж					
	Харуул, хамгаалалтын зардал					
	Банкны үйлчилгээний хураамж					
	Маягт хэвлүүлэх зардал					
	Хөрөнгийн төлбөр					
	Бусад зардал					
	<u>Тусгай материал, үйлчилгээний зардал</u>					
	Хичээлт сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал					
	Эрдэм шинжилгээний ажлын зардал					
	Ерөнхий боловсролын сургуулийн СБЗ					
	Зөвлөн эдлэл, нормын хувцас худалдан авах зардал					
	Хоолны зардал					
	Эмийн зардал					
	Уран бүтээлийн зардал					
	Гадаадын зочны зардал					
	Биейийн тамирын уралдаан, тэмцээний зардал					
	ОУ-ын суваг ашигласны төлбөр					
	Музейн үзмэр худалдан авах зардал					
	Түүх соёлын дурсгалт зүйлийг хамгаалах зардал					
	Соёл урлаг хөгжүүлэх зардал					
	Хүүхдийн ба баримтат киноны зардал					
	Хот суурингийн ерөнхий төлөвлөгөөний зардал					
	Гудамжны гэрэлтүүлэг, цэвэрлэгээний зардал					
	Хөтөлбөр болон төслийн дотоодын ургал зардал					
	Гэмт хэргээс сэргийлэх арга хэмжээ					
	Улсын тооллогын зардал					
	Улс орны гадаад сурталчилгааны зардал					
	Ургамал хамгааллын зардал					
	Мал аж ахуйн үржлийн зардал					
	Газрын хянан баталгаажуулах зардал					
	Ойн хортон устах, ойг арчлах зардал					
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардал					
	Салбарын төвлөрсөн арга хэмжээ					
	Бусад бараа үйлчилгээний зардал					
	<b>ЗЭЭЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨЛБӨР</b>					
	Дотоод зээлийн үйлчилгээний төлбөр					
	Зээлийн хүү					
	<b>ТАТААС, САНХҮҮЖИЛТ</b>					
	Засгийн газрын дотоод санхүүжилт					
	Тусгай зориулалтын бусад санхүүжилт					
	Гадаад шилжүүлэг					
	Олон улсын байгууллагын гишүүний татвар					
	Бусад санхүүжилт					
	Оюутны тэтгэлэг					
	Нэг удаагийн тэтгэмж, урамшуулал					

	Төлберийн чадваргүй иргэдийн өмгөөллийн зардал				
	Бусад				
	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)				
	ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)				
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
	Хөрөнгийн орлого				
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого				
	Бусад хөрөнгийн борлуулалтын орлого				
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)				
	<u>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</u>				
	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардал				
	Бараа материал, нөөцийн бараа худалдан авах зардал				
	Бараа материал				
	Нөөцийн бараа				
	<u>Хөрөнгийн бусад зардал</u>				
	Ойжуулалтын зардал				
	Геологи хайгуулын зардал				
	Байгаль хамгаалах төслийн зардал				
	Их засварын зардал				
	Төсвийн хөрөнгөөр				
	Өөрийн хөрөнгөөр				
	Хөрөнгийн бусад зардал				
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)				
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)				
	МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТЭНЦЭЛ (VII)=(III)+(VI)				
	САНХҮҮЖИЛТИЙН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ				
	Богино хугацаат зээлийн өглөг (цэвэр)				
	Үрт хугацаат зээлийн өглөг (цэвэр)				
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ				
	САНХҮҮЖИЛТИЙН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН (VIII)				
	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				

**4.4 ТЕЗ-ИЙН НЭГДСЭН ТӨСӨВЛӨСӨН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН, ХОЛБОГДОХ  
ТАЙЛБАР**

Хүснэгт 15

(мян.төг)

ҮЗҮҮЛЭЛТ	200.. оны гүйцэ- тгэл	200.. оны гүйцэт- гэл	200.. оны ХБГ	200.. оны тесөв	200.. оны таамаг- лал	200.. оны таамаг- лал
Эхний үлдэгдэл						
Тайлангийн хугацаанд нэмэгдэх						
Тайлангийн хугацаанд хасагдах						
Эцсийн үлдэгдэл						

**Хэсэг 5. /Эрхлэх асуудлын хүрээ/-ний ТЕЗ-ийн эрхлэх  
асуудлын хүрээнд хамаарах аж ахуйн тооцоотой  
байгууллагуудын төсвийн хураангуй нэгтгэл, холбогдох  
тайлбар**

---

**5.1 ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах аж ахуйн тооцоотой  
байгууллагуудын орлогын төсвийн хураангуй нэгтгэл, холбогдох тайлбар**

Хүснэгт 16

Орлогын нэр, төрөл	200.. оны гүйцэт- гэл	200.. оны гүйцэт- гэл	200.. оны төсөв	200.. оны ХБГ	200.. оны төсөв	200.. оны таамаг- лал	200.. оны таамаг- лал
Үндсэн үйл ажиллагааны орлого							
Туслах үйл ажиллагааны орлого							
Хүүгийн орлого							
Бусад өөрийн орлого							
<b>Нийт орлого</b>							

5.2 ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах аж ахуйн тооцоотой байгууллагуудын зарлагын төсвийн хураангуй нэгтгэл, холбогдох тайлбар

Хүснэгт 17

Д/д	Төсвийн зардлын төрөл	200.. оны гүйцэтгэл	200.. оны гүйцэтгэл	200.. оны төсөв	200.. оны ХБГ	200.. оны төсөв	200.. оны таамаглал	200.. оны таамаглал
1	Бүтээгдэхүүний зардал: 1 Бүтээгдэхүүний анги 2 Бүтээгдэхүүний анги 3 Бүтээгдэхүүний анги 4 Бүтээгдэхүүний анги 5 Бүтээгдэхүүний анги 6 Бүтээгдэхүүний анги							
2	Тэтгэвэр, тэтгэмж ба бусад шилжүүлгийн зардал 1 TAX-ын нэг хүүхдийн сургалтын төлбөр 2 Нэг удаагийн тэтгэмж урамшуулал							
3	Өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэхэд гарах зардал 1 Олон улсын байгууллагын гишүүний татвар 2 Урсгал засвар 3 Бүтцийн өөрчлөлтийн зардал							
4	Хөрөнгө оруулалт 1 Улсын төсвийн хөрөнгө оруулалт: 2 Тоног төхөөрөмж 3 Эд хогшил 4 Их засвар  Өөрийн хөрөнгөөр хийх хөрөнгө оруулалт: 1							
	Улсын шинжтэй зарлага							
	НИЙТ ЗАРЛАГЫН ТӨСӨВ							

## Хэсэг 6. Хавсралтууд

### Хавсралт 1.

[Эрхлэх асуудлын хүрээ]-нд хамаарах агентлаг, төсвийн байгууллагын жагсаалт

Д/д	Байгууллагын нэр

## Хавсралт 2.

**ТЭЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах байгууллагуудын 200.. оны төсвийн төслийн дэлгэрэнгүй /эдийн засгийн ангилалаар/**

Дансны код	Зардлын зүйл	Дэд салбар 1			Дэд салбар 2		ТЭЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зардал	Нийт
		ТБ-1	ТБ-2	ТБ-3	ТБ-4			
<b>Нийт зардал</b>								

Хавсралт 3.

**ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах аж ахуйн тооцоотой байгууллагуудын зарлагын төсвийн төслийн дэлгэрэнгүй /эдийн засгийн ангилалаар/**

Дансны код	Зардлын зүйл	Байгууллага 1	Байгууллага 2	Нийт
	<b>Нийт зардал</b>			
	<b>Санхүүжилтийн эх үүсвэр:</b>			
	Үндсэн үйл ажиллагааны орлого			
	Туслах үйл ажиллагааны орлого			
	Бусад орлого			

Сангийн сайдын 2005 оны 49 дугаар  
тушаалын 2 дугаар хавсралт

**ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН ТӨСВИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ  
ЗААВАР**

УХА0011

**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ**

**1.1. Зааврын зорилго**

Энэхүү зааврын гол зорилго нь Монгол улсын төсвийн төслийн бүрэлдэхүүн хэсэг болон тусгах Төсвийн ерөнхийлөн захирагч/ цаашид ТЕЗ гэж тэмдэглэнэ/-ын төсвийн төслийг боловсруулахад нь туслах явдал юм.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн төслөө боловсруулахдаа Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад эрхийн акт, Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 253 дугаар тушаал болон энэхүү зааврыг баримтална.

**1.2. Төсвийн төслийн зорилго, ач холбогдол**

ТЕЗ-ийн төсвийн төслийн зорилго нь Улсын Их Хурал, Засгийн газрын өмнө ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх бодлого, зорилт, үйл ажиллагаа болон түүнд шаардагдах хөрөнгө нөөцийг оновчтой тодорхойлж, үр дүнгийн гэрээ байгуулан ажиллах нөхцлийг бүрдүүлэх, үр дүнгийн төлөө хүлээх хариуцлагыг баталгаажуулахад оршино.

**1.3. Төсвийн төсөл боловсруулахад баримтлах зарчим**

Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн төслөө бэлтгэхдээ дараах зарчмыг баримтлан ажиллана. Үүнд:

- Төсвийн төсөлд тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, бодит байдлыг харуулсан, хоорондоо уялдсан байна.
- ТЕЗ-ийн нийлүүлэх бүтээгдэхүүн нь бодитой, үнэн зөв тодорхойлогдсон, Засгийн газрын болон салбарын стратегийн зорилт, хүрэх үр дүнтэй нийцсэн байна. Төсвийн төсөлд тусгагдсан бүтээгдэхүүн нь УИХ-аас төсөв хуваарилах үндэслэл болно.
- Төсвийн төсөлд өмнөх 2 жилийн төсвийн гүйцэтгэл, тухайн санхүүгийн жилийн төсөв, хүлээгдэж буй гүйцэтгэл болон дараагийн турван жилийн төсвийн төсөл, таамаглалын мэдээллийг багтаасан байна.
- Үндсэн баримт бичиг болон хавсралт дахь мэдээллийн уялдааг бүрэн хангасан байх ба ТЕЗ өөрийн үйл ажиллагааны онцлогтоо тохируулан энд заагднаас бусад нэмэлт тайлбар, хавсралтуудыг төсвийн төсөлд оруулж болно.

**1.4. Төсвийн төслийн мөнгөн илэрхийлэл**

Төсвийн төсөлд мөнгөн дүнг мянган төгрөгөөр илэрхийлнэ.

**1.5. Төсвийн төсөл ирүүлэх хугацаа**

Төсвийн ерөнхийлөн захирагч нь үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө болон төсвийн төслөө Засгийн газрын 2004 оны 73 дугаар тогтоолд заасан хугацаанд

буюу 8 дугаар сарын 15-ны дотор Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлнэ.

### **1.6 Төсвийн төслийг хянах**

Сангийн яам ТЕЗ-аас ирүүлсэн төсвийн төслийг хянаад 9 дүгээр сарын 1-ны дотор төсвийн ерөнхийлөн захирагчтай зөвшилцөнө. Сангийн яамтай харилцан тохиролцсны дараа төсвийн ерөнхийлөн захирагч бүр төсвийн төслөө эцэслэн боловсруулж Сангийн яам, Засгийн газарт хүргүүлнэ.

Сангийн яам харилцан зөвшилцсөн төсвийн төслийг нэгтгэн дараа жилийн улсын төсвийн баримт бичиг болон дунд хугацаанд баримтлах эдийн засаг, санхүүгийн үндсэн зорилтын төслийг бэлтгэн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн төслийг хянах зааварыг Сангийн сайдын тушаалаар тусад нь батлан мөрдүүлнэ.

### **1.7. Төсвийн төсөлд оруулах нэмэлт өөрчлөлт**

12 дугаар сарын 1-ны дотор УИХ-аас хууль гарган батласан улсын төсвийн баримт бичгийн бүрэлдэхүүн хэсэг нь төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн төсөвт байх ба төсвийн төслийг хэлэлцэх явцад орсон өөрчлөлтийг тусган 12 дугаар сарын 15-ны дотор эцэслэн Сангийн яаманд ирүүлнэ. Төсвийн төсөлтэй хамт төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны онцлогт тохируулан сарын санхүүжилтийн хуваарь бэлтгэн Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлнэ. Төсвийн бодлого, зохицуулалтын газар сарын санхүүжилтийн хуваарийг хянаж Сангийн сайдын тушаалаар батлуулан төсвийн ерөнхийлөн захирагч болон Сангийн яамны төрийн сангийн газарт хүргүүлнэ.


Сарын санхүүжилтийн хуваарь бэлтгэх явцад ТЕЗ эрхлэх асуудлын хүрээний байгууллага хооронд зардал шилжүүлэхгүй. Хэрэв шаардлагатай бол холбогдох өөрчлөлт болон шилжүүлэн зарцуулах асуудлыг УИХ-аас төсвийн баримт бичиг батлагдахаас өмнө Сангийн яамтай тохиролцсны үндсэн дээр шийдвэрлэнэ.

## ХОЁРДУГААР ХЭСЭГ: ТӨСВИЙН ТӨСЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ТЭДГЭЭРИЙН АГУУЛГА

### 2.1 Төсвийн төслийн бүрэлдэхүүн хэсгүүд

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийн бүрэлдэхүүн хэсгүүд болон тэдгээрийн уялдаа холбоог зураг 1-д харуулав. Төсвийн төслийн бүтцийг Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль болон Нэгдсэн төсвийн тухай хуультай нийцүүлэн боловсруулсан бөгөөд бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн загвар, агуулгыг 2.2 дугаар хэсэгт дэлгэрэнгүй тайлбарласан болно.

## Зураг 1



## 2.2 Бүрэлдэхүүн хэсгүүдийн агуулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөл нь үндсэн 5, нэмэлт 2 хэсэгтэй байна. Бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн агуулгыг дор тайлбарлав.

### Нүүр хуудас

Нүүр хуудсанд дараах мэдээллийг тусгана. Үүнд:

- Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр
- Төсвийн төслийн гарчиг
- Төсвийн төслийн хамрах хугацаа
- Төсвийн төслийг өргөн барьсан хугацаа

### Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн Мэдэгдэл

ТЕЗ төсвийн төслөө боловсруулан Сангийн яам, Засгийн газарт хүргүүлэхдээ мэдэгдэл гаргах бөгөөд уг мэдэгдэлд төсвийн төслийн талаар хуулиар хүлээсэн үүрэг, хариуцлага, ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний ирэх 3 жилийн зорилт, хүрэх үр дүн болон түүнд хүрэхийн тулд авч хэрэгжүүлэх арга хэмжээ, арга барилын талаар дурьдахын сацуу төсвийн төслийн бодитой, үнэн зөв, иж бүрэн байдлыг хариуцан гарын үсэг зурж баталгаажуулна.

Мөн мэдэгдэлд төсвийн дагалдах баримт бичигт тусгагдсан мэдээллийг хураангуй байдлаар харуулна. Тухайлбал, төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний нийт зарлагын хэмжээ, улсын төсөвт оруулах нийт орлогын хэмжээг төрөл тус бүрээр болон ТБУСТХ-ийн 15-р зүйлд заасан улсын шинжтэй зарлагын нийт төсөвлөсөн хэмжээ зэргийг хураангуй байдлаар тусгах ба нийт төсөвтэй эзлэх хувийн жинг мөн харуулсан байвал зохино. Хураангуй мэдээлэл нь баримт бичгийн үндсэн хэсгүүд болон хавсралтанд заасан тоо мэдээлэлтэй нийцсэн байна.

Энэ хэсэгт мөн дэд салбар бүрээр (хэрэв дэд салбар байхгүй бол эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, агентлагын төрлөөр, үйл ажиллагааны чиглэлээр гэх мэт) төсвийн орлого болон зарлагын төлөвлөгөөг хураангуйлан харуулна.

### Нэр томьёо ба товчилсон угийн тайлбар

Энэ хэсэгт цаашид олон удаа давтагдах үгсийн товчлол болон энэхүү баримт бичгийг уншигч, хэрэглэгч нарт мэдээлэл болгох зорилгоор гол нэр томьёог тайлбарын хамт харуулна.

### Хэсэг 1: Дунд хугацааны стратегийн зорилтууд, төсвийн төслийн уялдаа ба төсвийн хандлага

#### Хэсэг 1.1 Дунд хугацааны стратегийн зорилтууд

Энэ хэсэгт ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээ(салбар)-нд дунд хугацаанд дэвшүүлсэн стратегийн зорилт, хүрэх үр дүнг танилцуулахын зэрэгцээ эдгээр нь тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулах стратеги, Засгийн газрын мөрийн хөтөлбөртэй хэрхэн уялдсан, дунд болон урт хугацааны эрсдлийг хэрхэн тооцсон талаар тайлбарласан байна. Стратегийн зорилт бүрийн хувьд хүрэх үр дүнг хэмжигдэхүйц байдлаар маш тодорхой томьёолох ба тэргүүлэх ач холбогдолоор нь дараалуулан харуулна.

**Хэсэг 1.2 Дунд хугацаанд хэрэгжүүлэх зарлиг, хууль, тогтоол, захирамж, бусад холбогдох шийдвэрүүд**

Энэ хэсэгт мөн тухайн эрхлэх асуудлын хүрээнд дэвшүүлсэн дунд хугацааны стратегийн зорилт, нийлүүлэх бүтээгдэхүүн, төсвийн орлого, зарлагыг тодорхойлох гол үндэслэл болсон мөрдөж буй болон цаашид мөрдөх Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлиг, УИХ, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, бусад холбогдох шийдвэрийг танилцуулна. Эдгээр шийдвэр нь эрхлэх асуудлын хүрээний стратегийн зорилтууд, төсвийн төсөлтэй ямар хамааралтай болох, хэрхэн уялдсан талаар тайлбарлана.

**Хэсэг 1.3 Дунд хугацааны стратегийн зорилт ба төсвийн төслийн уялдаа**

Мөн ТЕЗ-ийн стратегийн зорилт, хүрэх үр дүн нь төсвийн төсөлтэй хэрхэн уялдаж буй талаар (Хүснэгт 1) болон нийлүүлэх бүтээгдэхүүн нь дэвшүүлж буй стратегийн зорилтыг хангахад ямар хувь нэмэр оруулах талаар тайлбарласан байна.

**Хэсэг 1.4 Төсвийн цаашдын хандлага, авах арга хэмжээ**

ТЕЗ-ийн төсвийн хэмжээ жилээс жилд ямар хандлагатай байгааг харуулахын тулд өмнөх 3 жилийн гүйцэтгэл, тухайн төсвийн жилийн төсөв болон хүлээгдэж буй гүйцэтгэл, ирэх 3 жилийн төсөв ба таамаглалыг нийт орлого болон зарлагаар тухайлбал, зарлагыг бүтээгдэхүүний, хөрөнгө оруулалтын, өмчлөлийн эрхийг хэрэгжүүлэх, тэтгэвэр, тэтгэмж ба бусад шилжүүлэг гэсэн 4 бүлэгт хуваан харьцуулан шинжлэх нь төсвийн хөрөнгийн хүрэлцээ, хуваарилалт, ашиглалт, төсөв ба салбарын стратегийн зорилтын уялдаа хэрхэн хангагдаж буйд үнэлгээ өгөхөд чухал ач холбогдолтой.

Дараах чиглэлээр төсвийн хандлагыг харуулсан байна. Үүнд:

- Нийт төсвийн хандлага
- Урсгал зардлын хандлага
- Улсын төсөвт төвлөрүүлэх нийт орлогын хандлага
- Бүтээгдэхүүний ёртгийн хандлага
- Хөрөнгө оруулалтын зардлын хандлага
- Тэтгэвэр, тэтгэмж ба бусад шилжүүлгийн зардлын хандлага болон
- Өмчлөлийн эрхийг хэрэгжүүлэхэд гарсан зардлын хандлага

Цаашдын хандлагыг хүснэгтээр, гарфикаар харуулж болно. Хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ нь төсөвт ямар зэрэг болон сөрөг хандлага бий болгож болох талаар болон ямар арга хэмжээ авч болох талаархи саналаа энэ хэсэгт мөн харуулна.

## **Хэсэг 2: ТЕЗ-ийн орлогын төсвийн төсөл, тэдгээрийн тайлбар**

Энэ хэсэг нь 2 дэд хэсэгтэй. Үүнд:

- Улсын төсөвт оруулах орлогын төсвийн төсөл, холбогдох тайлбар
- Өөрийн орлого, бусад нэмэлт орлогын төсвийн төсөл, тэдгээрийн тайлбар

**Хэсэг 2.1 Улсын төсөвт оруулах орлогын төсвийн төсөл, тэдгээрийн тайлбар**

Энэ хэсэгт тухайн эрхлэх асуудлын хүрээнд Монгол улсын хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөвт оруулах орлогыг тэдгээрийн төрлөөр өмнөх 2 жилийн гүйцэтгэл, тухайн оны хүлээгдэж буй гүйцэтгэл, ирэх оны төсөв болон дараагийн 2 жилийн таамаглалын хамт харуулна. Ирэх оны төсвийг

төсвийн хүрээ, санал, СЯ-наас хянасан болон УИХ-аар батлагдсан гэсэн 4 дэд баганатайгаар бэлтгэнэ. Энэхүү баримт бичиг нь УИХ-аас төсөв батлагдах хүртэл өөрчлөгдж болох тул холбогдох өөрчлөлтүүдийг тусгах үүднээс ирэх оны төсвийн хувьд 4 баганатайгаар бэлтгэх шаардлагатай тавигдаж байгаа болно. Зөвхөн орлогын хувьд ч бус бусад бүх тооцоо, төсөвт ирэх оны төсвийг мөн энэхүү 4 баганатайгаар бэлтгэнэ. Холбогдох тайлбарт төсвийн орлого ямар шалтгаанаар өссөн эсвэл буурсан болохыг тайлбарлана. Тухайлбал, хууль, тогтоомжийн хүрээнд гарсан өөрчлөлтөөс, үнийн өсөлт, бууралтаас гэх мэт.

Орлогын төсвийн төслийг Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 341 тоот тушаалаар батлагдсан орлогын дансны ангилал, кодын дагуу бэлтгэнэ (Хүснэгт 2).

## 2.2 Өөрийн орлого, бусад нэмэлт орлогын төсвийн төсөл, холбогдох тайлбар

Энэ хэсэгт эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, агентлагын өөрийн орлогыг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого, бусад эх үүсвэрээс орсон орлогоор ангилан өмнөх 2 жилийн гүйцэтгэл, тухайн оны хүлээгдэж буй гүйцэтгэл, ирэх оны төсөв болон дараагийн 2 жилийн таамаглалын хамт харуулна.(Хүснэгт 3). Бусад орлогыг мөн дэлгэрэнгүй байдлаар харуулах ба банкнаас дансны үлдэгдэлд төлсөн хүүгийн орлого, хандив, тусlamжийн орлого гэх мэт орлогууд багтана.

### **Хэсэг 3: ТЕЗ-ийн зарлагын төсвийн төсөл, тэдгээрийн тайлбар**

Хэсэг 3.1 Эрхлэх асуудлын хүрээний ТЕЗ-ийн зарлагын төсвийн төслийн хураангуй, холбогдох тайлбар

Энэ хэсэгт эрхлэх асуудлын хүрээний ТЕЗ-ийн ТБУСТХ-ийн 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан зарлагын төсвийн төслийг хураангуй байдлаар харуулна. Зарлагын төсвийн төслийн хураангуй дүн нь 3.2, 3.3, 3.4, 3.5, 3.6 болон 3.7 дахь хэсэгт заасан дэлгэрэнгүй дүнтэй тохирч байх ёстой.

Зарлагын төсвийн төсөл нь ТБУСТХ-ийн 30 дугаар зүйлийн 1.1-д заасны дагуу УИХ-аас баталсан дунд хугацааны Төсвийн хүрээний мэдэгдэлтэй нийцсэн байх ба 30 дугаар зүйлийн 1.7-1.9-д заасан ангилал тус бүрээр буюу бүтээгдэхүүний зардал, хөрөнгө оруулалтын зардал, өмчлөгчийн эрхийг хэрэгжүүлэхэд гарах зардал болон тэтгэвэр, тэтгэмж ба бусад шилжүүлгийн зардлын төрөл бус бүрээр боловсруулагдсан байна (Хүснэгт 4).

Энэ хэсэг нь дараах 5 дэд хэсгээс бүрдэх ба дэд хэсэг тус бүрийн агуулгыг дор тайлбарлав. Үүнд:

- ◆ Бүтээгдэхүүний ангийн төсвийн төсөл, холбогдох тайлбар
- ◆ Тэтгэвэр, тэтгэмж ба бусад шилжүүлгийн зардлын төсвийн төсөл, холбогдох тайлбар
- ◆ Өмчлөлийн эрхийг хэрэгжүүлэхэд гарах зардлын төсвийн төсөл, холбогдох тайлбар
- ◆ Хөрөнгө оруулалтын төсвийн төсөл, холбогдох тайлбар
- ◆ Улсын шинжтэй зарлагын төсвийн төсөл, холбогдох тайлбар

ТЕЗ-ийн төсвийн төслийг ТБУСТХ-ийн 30 дугаар зүйлтэй нийцүүлэн бэлтгэхийн тулд зарлагын эдийн засгийн ангилал дахь аль зардал нь бүтээгдэхүүний, хөрөнгө оруулалтын, өмчлөлийн эрхийг хэрэгжүүлэх болон тэтгэвэр, тэтгэмж ба бусад шилжүүлгийн болохыг зааглан тогтоо шаардлагатай бөгөөд энэ талаархи холбогдох журам, аргачлалыг Сангийн сайдын тушаалаар тусад нь батлан мөрдүүлнэ.

### Хэсэг 3.2 Бүтээгдэхүүний ангийн төсвийн төсөл, холбогдох тайлбар

Энэ хэсэгт эрхлэх асуудлын хүрээний ТЕЗ-ийн худалдан авах бүтээгдэхүүний анги, тэдгээрийн томьёолол, нийлүүлэгч этгээд болон бүтээгдэхүүний анги тус бүрийн төсөвт өргтийг харуулна. ТЕЗ-ийн худалдан авах бүтээгдэхүүний анги нь Засгийн газраас баталсан бүтээгдэхүүний ангитай нийцсэн байхаас гадна тухайн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд баталсан салбарын бүтээгдэхүүний ангилалтай нийцсэн байх ёстой.

Бүтээгдэхүүний нийлүүлэгч нь олон байх тохиолдолд, тухайлбал, боловсрол, эрүүл мэнд гэх мэт салбарын хувьд тусгай хавсралтаар бүтээгдэхүүн нийлүүлэгчийг үзүүлж болно.

ТЕЗ-ийн худалдан авах бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанар, байршил, хугацаа гэх мэт дэлгэрэнгүй мэдээллийг тухайн бүтээгдэхүүнийг нийлүүлэгч байгууллага бүрийн **Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө**-нд дэлгэрэнгүй тусгана. ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагуудын Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөө нь тухайн байгууллагын төсөв боловсруулах гол үндэслэл болох бөгөөд төсвийн ерөнхийлөн захирагч шийдвэр гаргах, үйл ажиллагааны үр дүнг нь үнэлэх, дүгнэх, төсвийг нэгтгэхэд шаардагдах гол мэдээлэл болно.

ТЕЗ өөрийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллагуудын стратегийн гол гол зорилтуудыг тодорхойлон төсвийн байгууллагуудтайгаа тохиролцох, ямар бүтээгдэхүүнийг худалдан авахаа тодорхойлох, худалдан авах бүтээгдэхүүний тоо хэмжээ, чанарын үзүүлэлтүүдийн талаар тохирох, зардлын тооцоо буюу бүтээгдэхүүний өргтийн төсөвтэй танилцаж зөвшөөрөх, тухайн бүтээгдэхүүнийг нийлүүлэх хэд хэдэн ижил терлийн нийлүүлэгч байгаа нөхцөлд өрсөлдөх чадвартай нийлүүлэгчийг сонгох, бүтээгдэхүүн нийлүүлэхэд хүлээх үүрэг, гарах эрсдлийг дүгнэх цэгнэх, төсвийн байгууллагын өмчлөлийн бусад зорилтыг тодорхойлж, зөвшөөрөх хариуцлагыг хүлээнэ.

ТЕЗ-ийн төслийн төсөлд тэдгээр бүтээгдэхүүнийг нийлүүлснээр **хүрэх үр дүн** буюу стратегийн зорилтыг, төсөвт өргтийнх нь хамт тусгана. Учир нь нэг ТЕЗ-д янз бүрийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг олон байгууллага хамаардаг ба тэдгээрийн нийлүүлэх бүтээгдэхүүний чанарын болон бусад хариуцлагыг Засгийн газрын нэрийн өмнөөс худалдан авагч болж буй ТЕЗ хүлээх хэдий ч энэхүү баримт бичигт бүгдийг нь нэг дор, дэлгэрэнгүй байдлаар үзүүлэх боломжгүй юм.

Бүтээгдэхүүний өргтийн төсвийн төсөл гэсэн хүснэгт (Хүснэгт 5) нь 8 баганатай байх ба эхний баганад бүтээгдэхүүний ангийн нэр, 2-6 дугаар баганад тухайн төсвийн жилийн өмнөх 2 жилийн төсвийн гүйцэтгэл, тухайн санхүүгийн жилийн хүлээгдэж буй гүйцэтгэл болон ирэх жилийн төсвийн төсөл ( төсвийн хүрээ, ТЕЗ-ийн санал, СЯ-наас хянасан, УИХ-аас баталсан гэсэн 4 дэд баганатай), дараагийн 2 жилийн төсвийн таамаглалыг, 8 дугаар баганад тухайн бүтээгдэхүүнийг нийлүүлэгчийг заана. Энэ нь аль бүтээгдэхүүнийг хэзээ ямар өртөгтэйгээр нийлүүлж байсан талаархи мэдээлэлээр хангахаас гадна харьцуулах боломжийг олгоно. Хэрэв төсөвт тодотгол хийж байсан бол хамгийн сүүлд тодотгосон дүнг тавина.

Энэ хэсэг дэх "Холбогдох тайлбар" гэсэн хэсэгт нийлүүлэх бүтээгдэхүүний ангийн тодорхойлолт буюу ямар үйл ажиллагаа болохыг тодорхойлон тухайн санхүүгийн жилийн хувьд бүтээгдэхүүн бүрт ямар онцлог үйл ажиллагаа хамаарч буйг заахаас гадна бүтээгдэхүүний анги тус бүрийн тоо хэмжээний талаархи мэдээллийг тусгана. Мөн Засгийн газрын болон салбарын бодлого,

зорилтоос хамаарч нэмэгдсэн эсвэл хасагдсан бүтээгдэхүүний нийлүүлэлтэнд гарах өөрчлөлтийг тусгана.

Мөн энэ хэсэгт нийлүүлэх бүтээгдэхүүнтэй уялдаа бүхий төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг Санхүү, эдийн засгийн сайдын 2004 оны 155 тоот тушаалаар батлагдсан үндсэн чиглэлийн үзүүлэлтийн дагуу харуулна (Хүснэгт 6).

**Хэсэг 3.3 Тэтгэвэр, тэтгэмж ба бусад шилжүүлгийн зардлын төсвийн төсөл, холбогдох тайлбар**

Энэ хэсэгт ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд зарцуулах тэтгэвэр, тэтгэмж, ба бусад шилжүүлэг, тусlamжийн зардлын төсвийг харуулна. Ихэнхи ТЕЗ нарт татаас буюу санхүүгийн дэмжлэг олгох эрх хязгаарлагдмал байдаг боловч зарим тохиолдолд ахмад настнуудад олгох тэтгэмж, ажиллагсадад олгох буцалтгүй тусlamж гэх мэт зардлууд гардаг бөгөөд энэхүү зардлуудыг урьдчилан төсөвлөж төсвийн төслийн энэ хэсэгт харуулна. Сангийн яамны ТЕЗ гэх мэт зарим ТЕЗ нарын хувьд орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, олон улсын байгууллагын шилжүүлгийн зардал гардаг тул тэдгээрийн энэ хэсэгт холбогдох тайлбарын хамт харуулна (Хүснэгт 7).

Тэтгэвэр, тэтгэмж ба бусад шилжүүлгийн зардлын төсвийг аймаг, орон нутгаар, татаас тусlamжийн төрлөөр, хүлээн авагч этгээдээр нь товчоолж харуулна.

**Хэсэг 3.4 Өмчлөлийн эрхийг хэрэгжүүлэхэд гарах зардлын төсвийн төсөл, холбогдох тайлбар**

Өмчлөлийн эрхийг хэрэгжүүлэхэд гарах зардал гэдгийг ТБУСТХ-ийн 4 дэх хэсгийн 1.15-д зааснаар "Улсын Их Хурлаас эрх олгосны дагуу Засгийн газар төсвийн хөрөнгийг захиран зарцууллагчийн хувьд төсвийн байгууллага өөрийн чиг үүргийн үйл ажиллагааг үр өгөөжтэй, тасралтгүй явуулж байх хүний нөөц, эд хөрөнгө болон санхүүгийн нөөцийг бүрдүүлэх, учирч болох эрсдэлийг удирдах арга хэмжээг төлөвлөн авч хэрэгжүүлэхийг" гэж тодорхойлсон. Энэ үйл ажиллагааны зардалд бүтцийн өөрчлөлтийн зардал, ажиллагсдын давтан сургалтын зардал, урсгал засварын зардал зэрэг байгууллагын хэвийн үйл ажиллагаанд ашиглагдах хүний нөөц болон хөрөнгийн нөөцийг сайжруулахад зарцуулах зардлуудыг багтана. Иймд ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээний байгууллага бүр эдгээр зардлыг төлөвлөн Үйл ажиллагааны хэтийн төлөвлөгөөндөө тусгах ба ТЕЗ өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн, хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэхэд чиглэгдсэн зардлуудыг нэгтгэн төсөвлөж холбогдох тайлбарын хамт энэ хэсэгт харуулна (Хүснэгт 8).

Өмчлөлийн эрхийг хэрэгжүүлэхэд гарах зардлыг дэд салбараар, аймаг, орон нутгаар, байгууллагаар, зардлын төрлөөр нь товчоолон харуулна.

**Хэсэг 3.5 Хөрөнгө оруулалтын төсвийн төсөл, холбогдох тайлбар**

Энэ хэсэгт тухайн төсвийн жилд хийх хөрөнгө оруулалтын төсвийг тэдгээрийн нэр төрлөөр, санхүүжилтийн эх үүсвэртэй хамтад нь харуулна. ТЕЗ өөрийн эрхлэх асуудлын хүрээний ямар агентлаг, төсвийн байгууллагад хөрөнгө оруулалт хийхээ маш тодорхой тусгасан байвал зохино. Энэ хэсэгт төсвийн хөрөнгө оруулалтыг тусгахаас гадна өөрийн хөрөнгөөр, хөтөлбөр, төслийн эх үүсвэрээр хийх нийт хөрөнгө оруулалтыг тусгана.

Хөрөнгө оруулалтын төсвийн төслийг заавар дахь Хүснэгт 9-т заасны дагуу боловсруулах ба энэ нь мөн 8 баганатай байх ба эхний баганад хөрөнгө оруулалтын нэр төрөл, 2-6 дугаар баганад тухайн төсвийн жилийн өмнөх 3

жилийн хөрөнгө оруулалтын төсвийн гүйцэтгэл, хүлээгдэж буй гүйцэтгэл болон ирэх жилийн төсвийн төсөл (төсвийн хүрээ, ТЕЗ-ийн санал, СЯ-наас хянасан, УИХ-аас баталсан гэсэн 4 дэд баганатай), дараагийн 2 жилийн төсвийн таамаглалыг, 8 дугаар баганад тухайн хөрөнгө оруулалт хийх объект буюу төсвийн байгууллагыг заана.

Энэхүү төсвийн төслийг хэрэглэгч нарт илүү тодорхой мэдээлэл өгөх зорилгоор хөрөнгө оруулалтын төсвийг хөрөнгө оруулалтын төрлөөр, дэд салбараар, аймаг, орон нутгаар, объектоор, хүлээн авагч байгууллагаар товчоолон харуулна.

Он дамжин баригдаж буй барилга, объект болон бусад хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг өссөн дүнгээр харуулна.

### Хэсэг 3.6 ТЕЗ-ийн төсвийн төсөл /эдийн засгийн ангилалаар/, холбогдох тайлбар

Энэ хэсэгт эрхлэх асуудлын хүрээний ТЕЗ-ийн зарлагын төсвийн төслийг салбар, дэд салбар, байгууллага, аймаг, нийслэлээр, эдийн засгийн ангилалын дагуу товчоолон хавсралтаар харуулна. Төсвийн зарлагын эдийн засгийн ангилал нь Сангийн яамнаас баталсан ангилалын дагуу холбогдох дансны кодтой байна.

Төсөвт байгууллагын тувшинд Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 253 тоот тушаалаар батлагдсан дансдын эдийн засгийн ангилал, кодын дагуу зарлагын төлөвлөгөөг хийх ба ТЕЗ-ийн тувшинд Санхүү, эдийн засгийн сайдын 2003 оны 341 тоот тушаалаар батлагдсан Төрийн сангийн дансны ангилал, кодтой уялдуулан өөрийн эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын зарлагын төсвийг нэгтгэнэ (Хүснэгт 10). Зарлагын эдийн засгийн ангилал, дансны кодод Сангийн яамнаас өөрчлөлт оруулсан тохиолдолд холбогдох өөрчлөлтийг тусгасан байвал зохино.

### Хэсэг 3.7 Улсын шинжтэй зарлагын төсвийн төсөл, холбогдох тайлбар

ТБУСТХ-ийн 15 дугаар зүйлд “Улсын төсвийн байгууллагаар дамжин төрийн нэрийн өмнөөс гүйцэтгэж буй ажил, үйлчилгээний орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийг улсын орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн тайланд тусгана” гэж заасан. Хуулийн энэ шаардлагын дагуу улсын нэрийн өмнөөс орлого цуглуулдаг эсвэл зарлага гаргадаг бүх агентлаг, тусгай зориулалтын сангуд болон төсвийн байгууллагууд энэхүү тайланг гаргах ба жилийн эхэнд улсын шинжтэй орлого, зарлага, хөрөнгө, өр төлбөрийн төсвөө бэлтгэсэн байна. Тухайлбал, Үндэсний татварын ерөнхий газар улсын нэрийн өмнөөс цуглуулах дотоодын бүх төрлийн татвар, хураамжийн, Гаалийн ерөнхий газар импортын бүх төрлийн татварын, Үндэсний статистикийн газар улсын нэрийн өмнөөс хүн амын тооллого, малын тооллогод гаргах зардлын, Улсын нийгмийн даатгалын ерөнхий газар улсын нэрийн өмнөөс олгох тэтгэвэр, тэтгэмжийн зардлын, Мэргэжлийн хяналтын газар хяналт шалгалтын акт, торгуулиар ногдуулах орлогын төсвийн төслөө боловсруулан энэ хэсэгт тусгана (Хүснэгт 11).

Тухайн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсвийн байгууллагууд өөрсдөө ажил үйлчилгээ гүйцэтгэснийхээ төлөө төсвөөс санхүүжилт авахын зэрэгцээ улсын нэрийн өмнөөс олох орлого, гаргах зардлын төсвийн төслөө хамаарах ТЕЗ-ийн төсвийн төсөлд нэгтгүүлэн улсын төсвийн баримт бичигт тусгуулна. Тухайн байгууллагын үйл ажиллагааны онцлог, төсвийн орлого, зарлагын тооцооны хэлбэрээс хамааран загварт үзүүлсэн хүснэгтээс өөр хэлбэрээр төслийг бэлтгэж болно.

## Хавсралт 2-ын үргэлжлэл



#### Хэсэг 4: ТЕЗ-ийн нэгдсэн төсөвлөсөн санхүүгийн тайлан, холбогдох нэмэлт тайлбар

Энэ хэсэгт ТЕЗ нь эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын төсвийн орлого, зарлагыг төлөвлөж, шаардлагатай тооцоог хийсний дараа улсын салбарын нягтлан бодох буртгэлийн олон улсын стандартын дагуу ТЕЗ-ийн нэгдсэн төсөвлөсөн санхүүгийн тайланг Санхүү, эдийн засгийн сайдын 2002 оны 253 тоот тушаалаар батлагдсан маят, зааврын дагуу боловсруулан холбогдох тооцоо, тайлбарын хамт харуулна.

Энэ нь үндсэн 4 тайлангаас бүрдэнэ. Үүнд:

- Төсөвлөсөн баланс (Хүснэгт 12)
- Төсөвлөсөн үр дүнгийн тайлан (Хүснэгт 13)
- Мөнгөн гүйлгээний төсөв (Хүснэгт 14)
- Төсөвлөсөн өмчийн өөрчлөлтийн тайлан (Хүснэгт 15)

Төсөвлөсөн тайлангийн нэмэлт тодруулгыг үр дүнгийн төсөвлөсөн тайлан ба төсөвлөсөн баланс дахь томоохон дүн бүхий эдийн засгийн гол гол үзүүлэлтүүдэд хийнэ. Тухайлбал, мөнгөн гүйлгээний төсвийг сараар, улирлаар, жилээр нэмэлт тодруулга болгон харуулна. Энэ нь санхүүжилтийн хуваарьтай нийцсэн байна.

#### Хэсэг 5: ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах аж ахуйн тооцоотой байгууллагуудын төсвийн төсөл, холбогдох тайлбар

Хэсэг 5.1 : ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах аж ахуйн тооцоотой байгууллагуудын орлогын төсвийн төслийн хураангуй нэгтгэл, холбогдох тайлбар

Энэ хэсэгт тухайн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах аж ахуйн тооцоотой байгууллагуудын орлогын төсвийн төслийг хураангуй байдлаар харуулна(Хүснэгт 16). Хураангуй нэгтгэл дэх дүн нь Хавсралт дахь дэлгэрэнгүй дүнтэй нийцэж байх ёстой.

Хэсэг 5.2 : ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах аж ахуйн тооцоотой байгууллагуудын зарлагын төсвийн төслийн хураангуй нэгтгэл, холбогдох тайлбар

Энэ хэсэгт тухайн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах аж ахуйн тооцоотой байгууллагуудын төсвийн төслийг ТБУСТХ-нд заасан ангилалын дагуу тэдгээрийг санхүүжүүлэх орлогын эх үүсвэртэй хамтад нь хураангуй байдлаар харуулна (Хүснэгт 17). Хураангуй нэгтгэл дэх дүн нь Хавсралт 3-т харуулсан дэлгэрэнгүй дүнтэй нийцэж байх ёстой. Хэрэв байгууллага нь төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой үйлдвэрийн газар бол ТБУСТХ-ийн 28 дугаар зүйлд заасны дагуу Зорилтын санал бэлтгэн Төрийн өмчийн хороонд хүргүүлнэ. Энэ төсвийн төслийг төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад хэлбэрээр зохион байгуулагдсан байгууллагууд гаргана.

#### Хэсэг 6: Хавсралтууд

Хавсралт хэсэгт тухайн ТЕЗ өөрийн үйл ажиллагааны онцлогоос хамаарч төсвийн төслийг дэмжих бусад холбогдох нэмэлт мэдээллийг харуулж болно. Хавсралт мэдээлэл нь төсвийн төслийн үндсэн хэсгүүд дэх мэдээлэлтэйгээ нийцсэн байх ёстой. Энэхүү зааварт 3 хавсралтыг үзүүлсэн бөгөөд Хавсралт 1-д [Эрхлэх асуудлын хүрээ]-нд хамаарах агентлаг, төсвийн байгууллагын

жагсаалтыг, Хавсралт 2-т зарлагын эдийн засгийн ангилалын дагуу бэлтгэсэн [Эрхлэх асуудлын хүрээ]-нд хамаарах агентлаг, төсвийн байгууллагын төсвийн төслийг харуулна.

Хавсралт 3-т ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах аж ахуйн тооцоотой байгууллагуудын төсвийн дэлгэрэнгүйг аймаг, нийслэл, байгууллагаар харуулна.

Ингэхдээ тухайн ТЕЗ-ийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах аж ахуйн тооцоотой байгууллагуудын төсвийн төслийг зарлагын эдийн засгийн ангилалын дагуу тэдгээрийг санхүүжүүлэх орлогын эх үүсвэртэй хамтад нь дэлгэрэнгүй байдлаар харуулна.

## Хавсралт 1. Төсвийн төлөвлөлтийн үе шатууд

